

I-III/2021


Тархаасан: 2021 оны 4 дүгээр сарын 14



2021 оны 3 дугаар сард экспорт 665.8 сая америк доллар боллоо

Монгол Улс 2021 оны эхний улиралд нийт 121 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 3.5 тэрбум америк доллар, үүнээс экспорт 2.0 тэрбум америк доллар, импорт 1.5 тэрбум америк долларыг эзэлж байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.3 (60.4%) тэрбум америк доллароор, экспорт 964.6 (93.1%) сая америк доллароор, импорт 362.1 (31.2%) сая америк доллароор тус тус өсжээ. Харин 2021 оны 3 дугаар сард экспорт 665.8 сая америк доллар, импорт 601.4 сая америк доллар болж, өмнөх сараас экспорт 28.8 (4.1%) сая америк доллароор буурч, импорт 138.0 (29.8%) сая америк доллароор өссөн байна.

Зураг 1. Экспорт, импорт, тэнцэл, сараар, сая америк доллар



Гадаад худалдааны тэнцэл 2020 оны эхний улиралд 125.8 сая америк долларын алдагдалтай байсан бол 2021 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 602.5 сая америк доллароор өсөж, 476.7 сая америк долларын ашигтай байна.


БНХАУ-тай 2021 оны эхний улиралд 2.4 тэрбум америк долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 69.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1. Экспортын хэмжээ, гол түнш улсаар, жил бүрийн эхний улирлын байдлаар

Улс орон	2019 I-III		2020 I-III		2021* I-III	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн	1 771.7	100.0	1 035.8	100.0	2 000.4	100.0
БНХАУ	1 520.4	85.8	904.7	87.3	1 850.3	92.5
Сингапур	7.4	0.4	5.8	0.6	49.9	2.5
БНСУ	6.0	0.3	4.2	0.4	32.3	1.6
ОХУ	14.9	0.8	11.0	1.1	27.8	1.4
АНУ	1.3	0.1	2.2	0.2	23.0	1.2
Бусад	221.8	12.5	107.9	10.4	17.1	0.9

БНХАУ-д экспортолсон бараа бүтээгдэхүүний 34.3 хувийг чулуун нүүрс, 33.6 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Сингапур улсад экспортолсон барааны 96.6 хувийг чулуун нүүрс, ОХУ-д экспортолсон барааны 41.1 хувийг жонш эзэлж байна.

Зураг 2. Уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, сая америк доллароор, жил бүрийн эхний улирлын байдлаар



Экспорт 2021 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 964.6 сая америк доллароор өсөхөд зэсийн баяжмалын экспорт 269.9 сая америк доллар, нүүрсний экспорт 439.4 сая америк доллароор нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Харин экспорт өмнөх сараас 28.8 сая америк доллароор буурахад зэсийн баяжмалын экспорт 25.9 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 2. Импортын хэмжээ, гол түнш улсаар, жил бүрийн эхний улирлын байдлаар


Улс орон	2019 I-III		2020 I-III		2021* I-III	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн	1 285.7	100.0	1 161.6	100.0	1 523.7	100.0
БНХАУ	372.6	29.0	336.5	29.0	595.9	39.1
ОХУ	363.0	28.2	389.6	33.5	409.6	26.9
Япон	139.8	10.9	88.0	7.6	117.0	7.7
БНСУ	53.5	4.2	46.0	4.0	59.6	3.9
АНУ	109.6	8.5	53.5	4.6	50.1	3.3
ХБНГУ	45.9	3.6	44.7	3.9	48.5	3.2
Бусад	201.3	15.7	203.2	17.5	243.0	15.9

Импортын дүнг авч үзвэл, 2021 оны эхний улиралд, БНХАУ 39.1, ОХУ 26.9, Япон Улс 7.7, БНСУ 3.9, АНУ 3.3 хувийг тус тус эзэлж, нийт импортын 80.9 хувийг бүрдүүлж байна.


ОХУ-аас импортоор оруулсан барааны 51.4 хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортолсон барааны 68.4 хувийг суудлын автомашин, БНХАУ-аас импортолсон барааны 5.7 хувийг цахилгаан эрчим хүч, 17.7 хувийг ачааны тэрэг, 76.6 хувийг олон нэр төрлийн бага жинтэй, бараа бүтээгдэхүүн эзэлж байна.

Импорт өмнөх оны мөн үеэс 362.1 сая америк доллароор өсөхөд улаан буудайн импорт 49.3 сая америк доллароор, ачааны автомашины импорт 90.7 сая америк доллар, суудлын автомашины импорт 22.1 сая америк доллароор өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 3. Импортын гол нэрийн нефтийн бүтээгдэхүүн, мянган тонноор, жил бүрийн эхний улирлын байдлаар



Зураг 4. Тээврийн хэрэгслийн импортын хэмжээ, ширхгээр, жил бүрийн эхний улирлын байдлаар



Эрдэс бүтээгдэхүүн, хүнсний бэлэн бүтээгдэхүүн, ургамлын гаралтай бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 93.1 хувийг эзэлж байгаа бол импортын 66.3 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт эзэлж байна.

Хүснэгт 3. Экспорт, импорт, зарим барааны бүлгээр, сая америк доллар, жил бүрийн эхний улирлын байдлаар

Үзүүлэлт	2019 I-III	2020 I-III	2021* I-III	2021* I-III / 2020 I-III %
Экспорт	1 771.7	1 035.8	2 000.4	193.1
Эрдэс бүтээгдэхүүн	1 478.9	886.0	1 776.2	2.0 ¹
Нүүрс	644.2	252.9	692.3	2.7 ¹
Зэсийн баяжмал	503.7	351.2	621.1	176.9
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	19.3	5.2	32.7	6.4 ¹
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	1.9	3.3	54.0	16.6 ¹
Нэхмэл бүтээгдэхүүн	32.5	25.6	35.7	139.7
Үнэт чулуу, металл, гоёлын зүйлс	196.0	80.4	27.4	34.1
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	195.9	80.4	25.7	31.9
Импорт	1 285.7	1 161.6	1 523.7	131.2
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	87.1	89.7	123.7	138.0
Эрдэс бүтээгдэхүүн	315.4	284.0	276.8	97.5
Автобензин	77.4	70.6	56.0	79.4
Дизелийн түлш	163.0	125.3	135.8	108.4
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлс	94.0	80.3	99.8	124.2
Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги	242.5	190.6	346.7	181.9
Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн	69.1	79.0	97.4	123.3
Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл	50.3	41.8	57.8	138.2
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл	281.3	240.7	263.0	109.2

¹ - Дахин их

Ойлголт, тодорхойлолт:

Гадаад худалдааны барааны нийт эргэлт: Экспорт, импортын нийлбэрээр тодорхойлно.

Гадаад худалдааны тэнцэл: Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

Импорт: Улсын материаллаг нөөцийг нэмэгдүүлэн, хилийн чанадаас эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааг тооцно. Нийт импортод гадаадын барааны шууд импорт, дотоодын барааны реимпорт багтана.

Экспорт: Улсын материаллаг нөөцийг хорогдуулан, эдийн засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа барааг тооцно. Нийт экспортод дотоодын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана.

Реимпорт: Өмнө нь экспортод бүртгэгдсэн дотоодын барааны импортыг ойлгоно.

Реэкспорт: Өмнө нь импортод бүртгэгдсэн гадаадын барааны экспортыг ойлгоно.

Эх орны үйлдвэрлэлийн бараа: Тухайн улс оронд импортоор оруулж, дахин боловсруулалт хийсэн, үндсэн чанар буюу техникийн шинжийг өөрчилсөн гадаад гаралтай барааг оруулна.

Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар



Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 5 дугаар сарын 15

*Эдийн засгийн статистикийн
газрын дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн
газрын статистикч Н.Адъяадорж
Утас : (976-51)-261563*